

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2021 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

МАЛЧИН ӨРХИЙГ ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭР БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ,
БАТАЛГААНЫ ТЭМДЭГ, МАЛЧИНД МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ
ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хувийнхаа өмчийн малыг байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг /малчин өрх/ үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох түүнийг хэрэглэх, мал аж ахуйн үйлдвэрлэл дээр тогтвор суурьшилтай ажиллаж байгаа мал маллагааны дадал туршлагатай 18-аас дээш насны малчин өрхийн гишүүнд /малчин/ мэргэжлийн үнэмлэх олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Журмын зорилго нь малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэн гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох замаар санхүү, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах, мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлтийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэжээллэг, аюулгүй хүнс, түүхий эдийг үйлдвэрлэж, нийлүүлэх, малын үүлдэрлэг байдлыг баталгаажуулж сайжруулах, ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, генетик нөөцийн биет болон биет бус үнэлгээг хийлгэх, үр шим, ашгийг тогтвортой хүртэх үйл ажиллагааг баталгаажуулахад оршино.
- 1.3. Малчинд мэргэжлийн үнэмлэх олгож малчдын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн мэдлэгийг тогтмол дээшлүүлэх, ур чадварыг үнэлэх, төрөөс малчинд урамшуулал, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход оршино.
- 1.4. Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох, малчинд мэргэжлийн үнэмлэх олгох үйл ажиллагааг бүх шатны Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох бүтцийн нэгж энэхүү журамд заасны дагуу эрхлэн зохион байгуулна.
- 1.5. Малчин өрхийн үндэсний үйлдвэрлэгчийн бүртгэлийн дугаарын эхний “1-6” орон нь аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны код байна. Кодыг нөхөхдөө мөрдөгдөж буй “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”-ыг ашиглана.

Хоёр. Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх

- 2.1. Малчин өрх үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлэх хүсэлтийг өөрийн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу бичгээр Хөдөө аж ахуйн тасагт гаргана.

2.2. Үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагч энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана.

2.2.1. Хүсэлт гаргагчийн иргэний үнэмлэхийн хуулбар

2.2.2. Оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргын тодорхойлолт

2.2.3. Тухайн оны жилийн эцэст тоологдсон малын тооны лавлагаа

2.2.4. Гэрчилгээ болон баталгааны тэмдэгтийн хураамж төлсөн баримт

2.3. Малчин өрх үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлэхэд дараах шаардлагыг хангасан байна.

2.3.1. Үндэсний үйлдвэрлэл эрхлэгч малчин өрх нь Татварын ерөнхий хууль, "Татвар төлөгчийг бүртгэх журам"-ын дагуу татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх;

2.3.2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулсан байх;

2.3.3. Үржлийн малын удам гарваль, ашиг шим, зүс, галбир, бие цогцос, үр төлийн чанарын үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, бүртгэлд хамруулсан байх;

Гурав. Малчинд мэргэжлийн үнэмлэх олгох

3.1. Хувийн өмчийн мал болон иргэн, хуулийн этгээдийн малыг гэрээ, түрээсээр жилийн 4 улиралд байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо бүрдүүлдэг 18-аас дээш настай Монгол Улсын иргэнд олгоно.

3.2. Малчны мэргэжлийн үнэмлэх нь дахин давтагдахгүй бүртгэлийн нэгдсэн дугаартай байх бөгөөд аймаг, нийслэл сум, дүүргийн кодыг бичиж сүүлийн дугаар нь 8 оронтой тоо байна. /АН-СД-00000000/

3.3. Малчин нь өөрийн нутаг дэвсгэрийн харьяалах Хөдөө аж ахуйн тасагт мэргэжлийн үнэмлэх авах хүсэлтээ бичгээр гаргана.

3.4. Хүсэлт гаргагч малчин журмын 3.2 дахь хэсэгт заасан хүсэлтэд дараах баримт бичгийг бүрдүүлэн хавсарган ирүүлнэ.

3.4.1. Өөрийн анкет /малчны мэдээлэл/

3.4.2. Иргэний үнэмлэхийн хуулбар

3.4.3. 1 хувь цээж зураг /3*4 хэмжээтэй/

3.4.4. Оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргын тодорхойлолт

3.4.5. Мэргэжлийн үнэмлэхийн хураамж төлсөн баримт

3.5. Мэргэжлийн үнэмлэх олгоход малчин дараах шаардлагыг хангасан байна.

3.5.1. Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл дээр 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж, мал маллагааны тодорхой арга туршлага хуримтлуулсан байх;

3.5.2. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ болон мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг байх;

Дөрөв. Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн эрхлэх үйл ажиллагаа

4.1. Хөдөө аж ахуйн тасаг нь үндэсний үйлдвэрлэгч малчин өрхөөр бүртгүүлэх, мэргэжлийн үнэмлэх авах асуудлаар харьяаллын дагуу бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, бичиг баримтын бүрдэл, шаардлагыг хангуулан аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ажлын 10 хоногт багтаан хүргүүлнэ.

4.2. Малчин өрхийн үндэсний үйлдвэрлэл эрхлэгчийн бүртгэл болон мэргэжлийн үнэмлэх олгосон малчдын бүртгэлийг баримт бичгийн цаасан болон цахим архивын санг үүсгэх, хөтлөх, холбогдох байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх ажлыг зохион байгуулах.

4.3. Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох, малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх үйл ажиллагаанд дэмжлэг, тусалцаа үзүүлэх, сурталчлах, тайлагнах ажлыг хэрэгжүүлэх.

Тав. Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эрхлэх үйл ажиллагаа

5.1. Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлэх санал холбогдох мэдээлэл болон мэргэжлийн үнэмлэх олгох малчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэж, баталгаажуулан Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

5.2. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрт малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох, малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх зэрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.

5.3. Үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлсэн малчин өрх болон малчдын талаар шаардлагатай судалгааг тогтмол явуулах, үр дүнг мэдээлэх, тайлагнах.

Зургаа. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх үйл ажиллагаа

6.1. Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг, малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх үйл ажиллагааны хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих.

6.2. Үндэсний үйлдвэрлэгч малчин өрх, малчдын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх, хөтлөх.

6.3. Батлагдсан загварын дагуу гэрчилгээ, баталгааны тэмдэг, мэргэжлийн үнэмлэхийг захиалан хэвлүүлэх, холбогдох шийдвэрийн дагуу орон нутагт хуваарилах, олгох үйл ажиллагаанд хяналт тавих.

6.4. Үндэсний үйлдвэрлэгч малчин өрх, малчдын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах талаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

6.5. Орон нутгийн мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчийн бүртгэлээс хасах асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэх.

Долоо. Малчин өрхийн үндэсний үйлдвэрлэгчийн гэрчилгээ, баталгааны тэмдгийг хэрэглэх

7.1. Малчин өрх нь үндэсний үйлдвэрлэгчээр бүртгүүлсэн гэрчилгээ, баталгааны тэмдгийг дараах үйл ажиллагаанд хэрэглэнэ. Үүнд:

- Санхүү, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах;
- Зах зээлд малын гаралтай аюулгүй хүнс, түүхий эдийг үйлдвэрлэж, нийлүүлэх;
- Малын үүлдэрлэг байдал, эрүүл мэндийг баталгаажуулж сайжруулах;
- Генетик нөөцийн биет болон биет бус үнэлгээг хийлгэх;
- Малын ашиг шимийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ашгийг тогтвортой хүртэх;

Найм. Малчин мэргэжлийн үнэмлэхийг хэрэглэх

8.1. Малчинд мэргэжлийн үнэмлэхийг дараах үйл тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

- Малчны хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх;
- Сургалтад хамруулах, ур чадварыг үнэлэх;
- Төрөөс малчинд урамшуулал, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгох;

Ес. Бусад

9.1. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухай асуудал хариуцсан бүтцийн нэгж нь жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор үйл ажиллагааг нэгтгэн тайлан гаргана.

9.2. Үндэсний үйлдвэрлэгчид гэрчилгээ, баталгааны тэмдэг, малчинд мэргэжлийн үнэмлэх хууль бусаар олгосон, хүчингүй баримт бичиг баталгаажуулсан, нэгдсэн бүртгэлд худал мэдээлэл оруулсан хуурамчаар үйлдсэн тохиолдолд хуулийн дагуу тухайн буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэж, олгосон гэрчилгээ, баталгааны тэмдэг, мэргэжлийн үнэмлэхийг хүчингүйд тооцно.

9.3. Үндэсний үйлдвэрлэгч малчин өрх, малчдыг дэмжих талаар төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хамрагдах, хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт нэн тэргүүнд хамруулах чиглэл баримтална.